**ОРХОН АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 07 сарын 31 -ны өдөр Дугаар А/182 Эрдэнэт

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 , Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.8 дах заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дах заалт, Засаг даргын А/476 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүн амын дунд урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажил үүргийн хуваарийг хоёрдугаар, урьдчилан сэргийлэх үзлэгийн удирдамжийг гуравдугаар, үзлэг зохион байгуулах бүдүүвч зураглалыг дөрөвдүгээр, шаардагдах төсвийг тавдугаар хавсралтаар тус тус батлсугай.
2. Урьдчилан сэргийлэх үзлэгийг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй гүйцэтгэж тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.
3. Урьдчилан сэргийлэх үзлэгтэй холбоотой 10.000.000 /Арван сая/ төгрөгийг нэмэлт санхүүжилтийн зардлаас гаргахыг Салбарын санхүү бүртгэл, мэдээлэл, нягтлан бодохын ажилтан /Н.Чулуун-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тооцон ажиллахыг хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.СҮХЭЭ

9043446 2070030036

My doc. EMG-iin dargiin tushaal

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны
02. дугаар сарын 21.-ны өдрийн
1/22 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

**Ажлын хэсгийн дарга:**

- Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга

**Гишүүд:**

- ЗДТГ-ын НБХ-ийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Баян-Өндөр сумын эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга
- Бусийн оношилгоо эмчилгээний төвийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга
- Бусийн оношилгоо эмчилгээний төвийн амбулаторийн тасгийн эрхлэгч
- Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нар
- Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн дарга
- Эрдэнэт сувилал цогцолборын ерөнхий эмч
- Хувийн хэвшлийн "Чандмань" холбооны тэргүүн
- Медипас эмнэлгийн ерөнхий эмч
- Эм холбооны тэргүүн
- Эх, хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- Эмийн бодлогын хэрэгжилт, чанар аюулгүй байдал, зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн
- Салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын ажилтан
- ЭМБМСС хариуцсан ажилтан
- Зураглаач

**Нарийн бичгийн дарга:**

- Нийгмийн эрүүл мэндийн төвийн халдварт бус өвчний асуудал хариуцсан ажилтан
- Нийгмийн эрүүл мэндийн төвийн Бэлгийн замаар дамжих халдвар, хүний дархлал хомсдолын вирусийн болон гэдэсний халдварт өвчний тандалт сэргийлэлт хариуцсан ажилтан

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны
02. дугаар сарын 21.-ны өдрийн
А/102дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

# АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

| Хариуцсан алба | Үндсэн ажлын чиг үүрэг | Хариуцах ажлын чиг үүрэг | Хэрэгжүүлэх хугацаа |
|---|---|---|---|
| Дарга | НЭМТ-ийн дарга | - Урьдчилан сэргийлэх үзлэгийн ерөнхий зохион байгуулалт, салбар дундын хамтын ажиллагааг хангах | 09.07- 09.24 |
| | | - Урьдчилан сэргийлэх үзлэгийн байрны зохион байгуулалт, бэлэн байдалд хяналт тавьж үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах боломжоор хангах | 09.07- 09.24 |
| | | - Урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулсан тухай ажлын тайланг нэгтгэж АЗДТГ-т хүргүүлэх | 09дүгээр сарын 30 |
| Нарийн бичиг | Халдварт бус өвчин тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн | - ХБӨ-ний талаарх иргэдийн мэдлэг хандлага, дадлыг үнэлэх тандалт судалгааг хийх<br>- Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах иргэдийн судалгааг нэгтгэх<br>- Урьдчилан сэргийлэх үзлэгт СӨЭМТ-өөс ашиглах багаж, тоног төхөөрөмж, үзлэгт хамтарч ажиллах нарийн мэргэжлийн эмч нарын судалгааг нэгтгэх, холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх<br>- ХБӨ-ний талаарх иргэдийн мэдлэг хандлага, дадлыг үнэлэх , хавдрын болон ХБӨ- ний эрт илрүүлгийн талаарх асуумжуудыг бэлтгэх<br>- Урьдчилан сэргийлэх үзлэгийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах боломжоор хангах | 09дүгээр сарын 04 |
| | Бэлгийн замаар дамжих халдвар, хүний дархлал хомсдолын вирусийн болон гэдэсний халдварт өвчний тандалт сэргийлэлт хариуцсан ажилтан | - Урьдчилан сэргийлэх үзлэгийн тайлан мэдээг нэгтгэх<br>- ХБӨ-ний талаарх иргэдийн мэдлэг хандлага, дадлыг үнэлэх тандалт судалгааг хийх<br>- Урьдчилан сэргийлэх үзлэгийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах боломжоор хангах | 09.07- 09.24 |
| Гишүүд: | ЗДТГ-ын эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн | - Урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулахад шаардлагатай санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх | 08 дугаар сарын 25 |

| | | | |
|---|---|---|---|
| | Баян-Өндөр сумын эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн | - Мөнхийн гэгээ, Энхжихмандирваа, Нийцэл ӨЭМТ-үүдэд урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах байр болон шаардлагатай ширээ сандал, хог хаягдлын уут саваар хангах | 08 дугаар сарын 27 |
| | | - Багийн нийгмийн ажилтнуудад харъяа өрхийн эрүүл мэндийн төвөөс ирүүлсэн судалгааны дагуу иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах үүрэг чиглэлийг өгч хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах | 09.07- 09.24 |
| | | - "Ковид -19" цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдварын сэргийлэлтийн дэглэмийг мөрдөхөд ЭМБ-уудтай хамтран ажиллаж зохион байгуулах | 09.07- 09.24 |
| | ЭТҮХ-ийн дарга | - Урьдчилан сэргийлэх үзлэг хийх нарийн мэргэжлийн эмч нарын хуваарийг батлуулж ЭМБ-уудад хүргүүлэх, эмч нарын оролцоог бүрэн хангаж ажиллуулах | 09 дүгээр сарын 01 |
| | | - Урьдчилан сэргийлэх үзлэгт шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн бэлэн байдал, хангалтыг зохион байгуулах, ЭМБ-уудыг үүрэгжүүлэх | 09 дүгээр сарын 04 |
| | | - Урьдчилан сэргийлэх үзлэгийн байрны зохион байгуулалт, бэлэн байдалд хяналт тавьж үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах боломжоор хангах | 09.07- 09.24 |
| | Эрүүл мэндийн газрын эх, хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн | - Урьдчилан сэргийлэх үзлэгийн дүгнэлтийн хуудас боловсруулж ӨЭМТ–үүдэд хүргүүлэх | 09 дүгээр сарын 04 |
| | | - Урьдчилан сэргийлэх үзлэгийн дүгнэлтийг ЭМБ-уудын дарга нараас авч нэгтгэн үр дүнг тайлагнах | 09дүгээр сарын 30 |
| | | - Урьдчилан сэргийлэх үзлэгийн байрны зохион байгуулалт, бэлэн байдалд хяналт тавьж үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах боломжоор хангах | 09.07- 09.24 |
| | Эрүүл мэндийн газрын эмийн бодлогын хэрэгжилт, чанар аюулгүй байдал, зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн | - Төсөвт заагдсан, эм, урвалж оношлуур, эмнэлгийн хэрэгслийн нийлүүлэх, ӨЭМТ-үүдэд хуваарилах, зарцуулалтад хяналт тавьж ажиллах | 09. 04 -09.27 |
| | Салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын ажилтан | - Төсөвт заагдсан, эм, урвалж оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, эмч, сувилагчдын ажлын хөлс, хоол хүнсний зардлыг шилжүүлэх, зарцуулалтад хяналт тавьж санхүүгийн зөрчил дутагдал гаргахгүй байх | 09. 04 -09.27 |
| | Нийгмийн эрүүл мэндийн төвийн | - Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өртөөг хариуцан | 09. 07 -09.24 |

| | | | |
|---|---|---|---|
| | ЭМБМСС хариуцсан ажилтан | ажиллаж МСС зохион байгуулах<br>- Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх гарын авлагыг ЭМБ-уудад хувиарлаж иргэн бүрт хүртээмжтэйгээр олшруулан бэлтгэх<br>- Урьдчилан сэргийлэх үзлэгийн үеэр хүн амын дунд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулах<br>- ХБӨ-ний талаарх иргэдийн мэдлэг хандлага, дадлыг үнэлэх тандалт судалгааг хийх | |
| | Нийгмийн эрүүл мэндийн төвийн зураглаач | - Урьдчилан сэргийлэх үзлэгийн талаарх мэдээллийг өргөн цар хүрээтэй сурталчилах, баримтжуулах | 09.05- 09.24 |
| | | - Мэдээлэл сургалт, сурталчилгаа, тандалт судалгаа хийхэд шаардлагатай техник хэрэгслийн бэлэн байдлыг холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран хангах | Тухай бүр |
| | | - МСС-ны эх бэлтгэлийг бэлтгэх | 09.01- 09.05 |
| | - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн амбулаторийн тасгийн эрхлэгч<br>- Эрдэнэт сувиллын цогцолборын ерөнхий эмч<br>- ХХЭМБ-уудын Чандмань-Эрдэнэ холбооны тэргүүн<br>- Медипас эмнэлгийн ерөнхий эмч | - Урьдчилан сэргийлэх үзлэг хийх нарийн мэргэжлийн эмч нарыг ЭМГ-аас баталсан хуваарийн дагуу томилж ажил үүргийг зохицуулах, үүрэгжүүлэх<br>- Урьдчилан сэргийлэх үзлэгт шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн бэлэн байдал, хангалтыг зохион байгуулах | 09.07- 09.24 |
| | | - Урьдчилан сэргийлэх үзлэгийн дүгнэлтийг нарийн мэргэжлийн эмч нараас авч нэгтгэн Эрүүл мэндийн газрын Эх, хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн П.Хишгээд илгээх | 09 дүгээр сарын 28 |
| | Сум, Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нар | - Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах иргэдийн судалгааг гаргаж ХБӨТСХА Н.Мөнгөнцацралтад munguunasaa@gmail.com хаягаар илгээх<br>- Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах иргэдийн судалгааг багийн нийгмийн ажилтанд хүргүүлж үзлэгт хамрагдах иргэдийн оролцоог бүрэн хангах, мэдээллийн зөв тогтолцоог нэвтрүүлэх<br>- Урьдчилан сэргийлэх үзлэгт өөрийн өрхөөс ашиглаж болох багаж, тоног төхөөрөмж, үзлэгт хамтарч ажиллах нарийн мэргэжлийн эмч нарын судалгааг ХБӨТСХА Н.Мөнгөнцацралтад | 09дүгээр сарын 04 |

| | | | |
|---|---|---|---|
| | | munguunasaa@gmail.com хаягаар ирүүлэх | |
| | | - Урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах байрыг ЭМГ-ын даргын тушаалд заасан будуувч зураглалын дагуу эрүүл аюулгүй, тав тухтай, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, хөндлөнгийн саадгүй орчин нөхцөлд бүрдүүлж үзлэг эхлэхээс 8 цагийн өмнө ажлын хэсэгт танилцуулах | Тухай бүр |
| | | - Зүрх судас, ЭКГ, Мэдрэл, Эмэгтэйчүүд, Дотор, ЭХО, Нүдний нарийн мэргэжлийн эмчийн үзлэг болон хөтөчөөр ажиллах сувилагчдыг томилох | Тухай бүр |
| | | - "Ковид -19" цар тахлаас урьдчилан сэргийлэх халдварын сэргийлэлтийн дэглэмийг чанд сахиулах, шаардлагатай хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйжүүлэлтийн бодисын нөөцийг бэлтгэх, үзлэгийн байранд 2 ажилтан томилж үүрэгжүүлэх | Тухай бүр |
| | Медипас эмнэлгийн ерөнхий эмч | - Хавдрын болон ХБӨ- ний эрт илрүүлгийн талаарх асуумж судалгааг боловсруулж ХБӨТСХА Н.Мөнгөнцацралтад munguunasaa@gmail.com хаягаар ирүүлэх | 8.28-9.02 |
| | Эм холбооны тэргүүн | - Эрүүл мэндийн сургалт сурталчилгааны материалыг олшруулах<br>- Хүний нөөцөөр дэмжлэг үзүүлэх<br>- СӨЭМТ-үүдэд шаардлагатай эм эмнэлгийн хэрэгслийн дэмжлэг үзүүлэх | 09.01-09.24 |

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны
09...дугаар сарын 11..-ны өдрийн
A/82 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

# ХҮН АМЫН ДУНД УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

**Үндэслэл :**

Эрүүл мэндийн Сайдаас 2020 онд аймгийн Засаг даргатай байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд хүн амын дунд зонхилон тохиолдож буй өвчлөл тухайлбал, элэг, хөх, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийг өмнөх онтой харьцуулахад 10 хувиар, чихрийн шижин, цусны даралт ихсэх өвчнийг эрт илрүүлэх үзлэгийн түвшинг 15 хувиар нэмэгдүүлэх зорилтот арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэж тусгасан боловч дэлхий дахинаа “Ковид-19” цар тахал дэгдэж улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдал зарлагдаж хөл хорионы дэглэмд шилжсэнтэй холбоотойгоор урьдчилан сэргийлэх үзлэг нийт давхардсан тоогоор 90396 хийгдэж, өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар буурсан, халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг 2020 оны эхний 5 сарын байдлаар артерийн даралт ихсэх өвчнийг илрүүлэх үзлэгт 27169 хүн хамруулахаар төлөвлөснөөс 9921 хүн хамрагдаж өмнөх оноос 0.6 хувиар нэмэгдсэн, чихрийн шижин хэв шинж-2 өвчнийг илрүүлэх үзлэгт 34474 хүн хамруулахаар төлөвлөснөөс 9638 хүн хамрагдаж өмнөх оноос 7.3 хувиар буурсан, хөхний өмөнгийн эрт илрүүлэгт 27545 хүн хамрагдахаас 7121 хүн хамрагдаж өмнөх оноос 12.8 хувиар буурсан, умайн хүзүүний эрт илрүүлэгт 6084 хүн хамрагдахаас 1976 хүн хамрагдаж өмнөх оноос 3.3 хувиар буурсан байна.

Сүрьеэгийн өвчлөл 2020 оны эхний хагас жилийн байдлаар 10000 хүн амд 3,3 промилл буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,2 промиллоор буурсан. Сүрьеэгийн үзлэгт 6339 хүн хамрагдсанаас 2295 (36,2%) нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10,9 хувиар буурсан.

**Зорилго :** Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлгийг эрчимжүүлж хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгааныг бууруулах

**Зорилт :**

1. Хүн амын дунд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулна.
2. Сүрьеэ болон БЗДХ-ын эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
3. Урьдчилан сэргийлэх үзлэгийн дүгнэлтэд үндэслэн иргэдийг эмчлэн эрүүлжүүлэх, диспансерийн хяналт авах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

**Хамрах хүрээ:** Орхон аймгийн 21 багийн 7600 иргэд
**Хаана, хэзээ:** Багуудын соёлын төвүүдэд 2020 оны 09дүгээр сарын 07-ноос 09 дүгээр сарын 24-ны өдрүүдэд

**Хамтран ажиллах байгууллагууд:**

1. ЗДТГ
2. Баян Өндөр сумын ЗДТГ
3. ЭМГ
4. БОЭТ
5. Сум, Өрхийн эрүүл мэндийн төвүүд
6. ХХЭМБ-ууд
7. Эм холбоо
8. Эрдэнэт сувилал цогцолбор

**Хамтран ажиллах байгууллагуудын гүйцэтгэх үүрэг чиглэл**

**ЗДТГ :**

1. Урьдчилан сэргийлэх, үзлэг, эрт илрүүлэг үзлэг шаардлагатай төсөв санхүүгийн асуудлыг шийдвэрлэх
2. Хамтран ажиллах байгууллагуудыг үүрэгжүүлэх, чиглүүлэх

**Баян-Өндөр сумын ЗДТГазар:**

1. Урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах байр болон шаардлагатай ширээ сандал, хог хаягдлын уут саваар хангах
2. Багийн нийгмийн ажилтнууд нь өөрийн харъяалалын хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, "Ковид -19" цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдварын сэргийлэлтийн дэглэмийг мөрдөхөд ЭМБ-уудтай хамтран ажиллаж зохион байгуулах

**Эрүүл мэндийн газар:**

1. Урьдчилан сэргийлэх үзлэгийг ерөнхий удирдлага, зохион байгуулалтаар хангах
2. Урьдчилан сэргийлэх үзлэгийн нарийн мэргэжлийн багийг томилж, багаж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангуулах
3. Үзлэгийн дүгнэлтийг нэгтгэх, үр дүнг тооцох, тайлагнах
4. Оношлууруудыг хувиарлах

**Бүсийн оношилгоо эмчилгээний төв, ХХЭМБ-ууд :**

1. Нарийн мэргэжлийн эмч нарыг гаргаж, хуваарийн дагуу ажиллуулах, эмч нарын ажлын цагийг зохицуулах
2. Шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангах

**Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд:**

1. Өөрийн харъяалалын хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, "Ковид -19" цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдварын сэргийлэлтийн дэглэмийг багийн нийгмийн ажилтнуудтай хамтран зохион байгуулах
2. Зорилтот бүлгийн хүмүүстээ урилга хүргүүлэх , үзлэгт хамрагдах иргэдийн судалгаа, чиглэлийг урьдчилан ирүүлэх
3. Урьдчилан сэргийлэх үзлэгт эмч, ажилчдаа дайчлах, бэлэн байдлыг хангуулах

4. Үзлэг хийх нарийн мэргэжлийн эмч нарын нэрс, шаардагдах багаж тоног төхөөрөмжийн судалгааг ЭМГ-т ирүүлэх

**Эм холбоо:**

1. Эрүүл мэндийн сургалт сурталчилгааны материалыг олшруулах
2. Хүний нөөцөөр дэмжлэг үзүүлэх

**Эрдэнэт сувилал цогцолбор:**

1. Үзлэг хийх нарийн мэргэжлийн эмч нарын нэрс, шаардагдах багаж тоног төхөөрөмжийн судалгааг ЭМГ-т ирүүлэх

**Урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлгийн чиглэл :**

1. Дотор -2 /уушиг, зүрх судас/ их эмч
2. Мэдрэл -2 их эмч
3. Нүд -2 их эмч
4. Чих хамар хоолой -2 их эмч
5. Халдварт өвчний эрт илрүүлэг үзлэг / Сүрьеэ -1, БЗДХ- 1, рентген техникч/
6. ЭХО -2 их эмч
7. Эмэгтэйчүүд-1 их эмч
8. Халдварт бус өвчлөлийн эрсдэлт хүчин зүйлийн үнэлгээ – 2 ажилтан

**Урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах хугацаа, байршил**

| № | | **9 дүгээр сарын 07-24** | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 07 | 08 | 09 | 10 | 11 | 14 | 15 | 16 | 17 | 18 | 21 | 22 | 23 | 24 |
| 1 | Нийцэл ӨЭМТ | | | | | | | | | | | | | | |
| 3 | Анхны-Оч ӨЭМТ | | | | | | | | | | | | | | |
| 4 | Үйлсбадрах ӨЭМТ | | | | | | | | | | | | | | |
| | Мөнхийн гэгээ ӨЭМТ | | | | | | | | | | | | | | |
| 5 | Мөнхсүндрэл ӨЭМТ | | | | | | | | | | | | | | |
| 6 | Учралтбаяр ӨЭМТ | | | | | | | | | | | | | | |
| 7 | Энхжихмандирваа ӨЭМТ | | | | | | | | | | | | | | |
| 8 | Мэндцэцэн ӨЭМТ | | | | | | | | | | | | | | |
| 9 | ЖСЭМТ | | | | | | | | | | | | | | |

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны
01..дугаар сарын .31.-ны өдрийн
А/02 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

**Урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах ажлын бүдүүвч зураглал**



Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны
01..дугаар сарын .31.-ны өдрийн
А/12 дугаар тушаалын тавдугаар хавсралт

| № | Зардлын нэр | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|
| **Үзлэг зохион байгуулах эмч, ажиллагсадын хоол, хүнс , ажлын хөлс** | | | | | |
| 1 | Цайны завсарлага | ш | Өдөрт 1 удаа / 20 хүн / 14 хоног | 3000 | 840.000 |
| 2 | Үдийн хоол | ш | Өдөрт 1 удаа / 20 хүн / 14 хоног | 10.000 | 2.800.000 |
| 3 | Ажлын хөлс | ш | 20 хүн/ 14 хоног | 10.000 | 2.800.000 |
| | | | Нийт | | 6.440.000 |
| **Үзлэгийн хэрэгсэл** | | | | | |
| 4 | Duo тест | ш | 1000 | 2.950 | 2.950.000 |
| 5 | U ёроолтой самбар | ш | 100 | 2930 | 293.000 |
| 6 | TPHA lab -21 | ш | 1 | 103.000 | 103.000 |
| 7 | ЭХО – Гель | ш | 10 | 9100 | 91.000 |
| 8 | Санитоль | л | 10 | 7300 | 73.000 |
| | | | Нийт | | 3.510.000 |
| Бичиг хэргийн зардал | | | | | |
| 9 | Анонс | ш | 1 | 50.000 | 50.000 |
| | | | Нийт | | 50.000 |
| **Нийт төсөв – 10.000.000төгрөг** | | | | | |

ТӨСӨВ БОЛОВСРУУЛСАН:

ХБӨТСХА: [signature] Н.Мөнгөнцацралт

ХЯНАСАН:

ЭЗТТХМ: [signature] Д.Отгондэлгэр